



Долоо хоног тутмын хэвлэл
2016 оны 08 дугаар сарын 26
№ 32 /941/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол

1769

Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол

1792

Журам батлах тухай

**Төрөөс хүн амын хөгжлийн
талаар баримтлах бодлого
батлах тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

610.	Журам батлах тухай	Дугаар 249	1769
611.	Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого батлах тухай	Дугаар 261	1792
612.	Журам шинэчлэн батлах тухай	Дугаар 276	1802
613.	Журам батлах тухай	Дугаар 288	1808
614.	Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай	Дугаар 292	1810
615.	Нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай	Дугаар 293	1811
616.	Журамд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 314	1812

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 05 дугаар
сарын 9-ний өдөр

Дугаар 249

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд холбогдох зааврыг баталж мөрдүүлэхийг Сангийн сайд Б.Болорт, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

САНГИЙН САЙД

Ч.САЙХАНБИЛЭГ

Б.БОЛОР



Засгийн газрын 2016 оны 249 дүгээр
тогтоолын хавсралт

ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Төрийн захиргааны төв болон Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага (цаашид “захиргааны байгууллага” гэх) Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6.2, 6.3, 6.4.1-6.4.3, 6.5.1, 6.5.2-т заасан урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулахтай холбогдсон нийтлэг харилцааг энэхүү журмаар зохицуулна.

2. Энэ журмын 1-д заасан хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулахад хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль тогтоомж болон энэ журмыг дагаж мөрдөнө.

3. Улсын төсвийн төслийг боловсруулахад Төсвийн тухай хуулийг дагаж мөрдөнө.

4. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулахад Засгийн газрын 2010 оны 123 дугаар тогтоолоор баталсан “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах нийтлэг журам”-ыг дагаж мөрдөнө.

5. Орон нутгийн төсвийн төслийг боловсруулахад Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ыг дагаж мөрдөнө.

6. Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, хөтөлбөрийн төслийг боловсруулахад Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ыг дагаж мөрдөнө.

7. Засгийн газрын гадаад тусламжийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, хөтөлбөрийн төслийг боловсруулахад Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ыг дагаж мөрдөнө.

8. Энэ журмын 1-д заасан хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах үйл ажиллагаанд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 5.1-д заасан зарчмыг баримтална.

9. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

9.1. “төсөл” гэж захиргааны байгууллагаас боловсруулж байгаа энэ журмын 1-д заасан хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн эх бичвэрийг;

9.2. “ерөнхий мэдээлэл” гэж бодлогыг оновчтой тодорхойлох зорилгоор төслийг боловсруулах үеийн эдийн засаг, нийгмийн нөхцөл байдлыг тодорхойлсныг;

9.3. “нөхцөл байдлын дүн шинжилгээ” гэж асуудлын шалтгаан, үр нөлөөг тоон болон чанарын мэдээлэлд үндэслэн хамрах хүрээний хамт тодорхойлсон бодлогын хувилбар боловсруулахад ашиглах судалгааг;

9.4. “бодлогын зорилт” гэж асуудлыг хэсэгчлэн болон бүрэн шийдвэрлэхэд чиглэсэн Засгийн газраас аливаа бодлогын хүрээнд дэвшүүлсэн оновчтой, хэмжиж болохуйц, тодорхой хугацаанд хүрч болохуйц эерэг өөрчлөлтийг;

9.5. “бодлогын үр нөлөө” гэж бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчны хүрээнд бий болох өөрчлөлтийг;

9.6. “бүтээгдэхүүн” гэж бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагаас авсан арга хэмжээний хүрээнд холбогдох талуудад нийлүүлж байгаа бараа, ажил, үйлчилгээг;

9.7. “орц” гэж зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн болон хүний нөөц, эдийн болон эдийн бус хөрөнгийг;

9.8. “шалгуур үзүүлэлт” гэж хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрт бий болох өөрчлөлтийг хэмжихээр төсөлд заасан чанарын болон тоон үзүүлэлтийг;

9.9. “суурь түвшин” гэж төслийг боловсруулах үеийн шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утгыг;

9.10. “зорилтот түвшин” гэж бодлогыг хэрэгжүүлэх явцад болон хэрэгжиж дуусахад хүрэхээр хүлээгдэж байгаа өөрчлөлтийг төсөлд тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн чанарын болон тоон утгыг;

9.11. “нөлөөллийн урьдчилсан үнэлгээ” гэж бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчин, аливаа байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, эрх зүйн орчинд үзүүлэх нөлөөллийн талаарх судалгааг;



9.12. “бодлогын хувилбар” гэж нөхцөл байдлын дүн шинжилгээ болон нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд үндэслэн асуудлыг шийдвэрлэхээр санал болгосон бодлогын 2-оос дээш сонголтүүдыг.

Хоёр. Төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах

10. Захиргааны байгууллага төслийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу санаачлан боловсруулах бөгөөд төслийг боловсруулахдаа уг төслийг хэрэгжүүлэх хүний нөөц, чадавхтай уялдуулна.

11. Засгийн газар Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын төслийг, төрийн захиргааны төв байгууллага төрөөс баримтлах бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлогын төслийг, төрийн захиргааны төв байгууллага болон Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн захиргааны байгууллага үндэсний хөтөлбөрийн төслийг, Засаг дарга аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын баримт бичгийн төслийг тус тус боловсруулна.

12. Захиргааны байгууллага нь дараах төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг холбогдох хууль тогтоомжид хамтран боловсруулахаар заасан болон бусад захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн, судлаач, мэргэжлийн холбоод, бодлогын баримт бичиг батлагдсанаар ашиг сонирхол нь хөндөгдөж болохуйц этгээдийн төлөөлийг оролцуулан байгуулж, удирдамжаар ханган, үйл ажиллагаанд нь хяналт тавина:

- 12.1. төрөөс баримтлах бодлого;
- 12.2. бүсчилсэн хөгжлийн бодлого;
- 12.3. үндэсний хөтөлбөр.

13. Засаг дарга нь дараах төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Тамгын газар, Засаг даргын дэргэдэх агентлаг, төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн, судлаач, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулан байгуулж, удирдамжаар ханган, үйл ажиллагаанд нь хяналт тавина:

- 13.1. аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт;
- 13.2. дэд хөтөлбөр.

14. Захиргааны байгууллага Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6.2, 6.3-т заасан хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх, бодлогын хувилбарыг боловсруулах ажлыг эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагаар гүйцэтгүүлнэ.

15. Захиргааны байгууллага төсөл боловсруулах ажлыг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг төлөвлөсөн байна.

16. Хөгжлийн бодлогын баримт бичгийг батлах эрх бүхий этгээд бодлогын хувилбаруудаас Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 17.1.3 дахь заалтыг үндэслэн оновчтой хувилбарыг нь сонгоно.

Гурав. Төсөл боловсруулах төлөвлөгөө

17. Энэ журмын 12, 13-т заасан Ажлын хэсэг нь төсөл боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөтэй байна.

18. Төсөл боловсруулах үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа болон хариуцан гүйцэтгэх, оролцох талын нэрийн хамт тусгана:

18.1. нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх;

18.2. нөхцөл байдлын дүн шинжилгээнд үндэслэн хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилтыг тодорхойлох;

18.3. хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх бодлогын хувилбаруудыг боловсруулах;

18.4. бодлогын хувилбаруудад нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийх;

18.5. хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах;

18.6. хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн талаар олон нийтийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулах.

19. Ажлын хэсэг төсөл, бодлогын хувилбаруудын төслийг эцэслэн боловсруулж, холбогдох хавсралтын хамт захиргааны байгууллагад хүлээлгэн өгөх.

Дөрөв. Нөхцөл байдлын дүн шинжилгээ

20. Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийхдээ тухайн бодлогын баримт бичигт тусган шийдвэрлэх эдийн засаг, нийгэм, эсхүл тодорхой зорилтот бүлэгт урт, дунд хугацаанд тулгамдаж байгаа зайлшгүй шийдвэрлэх хүндрэл, бэрхшээлийг мэдэрч, асуудлыг судалж тодорхойлно. Энэхүү



судалгаанд өмнө нь уг асуудлаар хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, статистик судалгаа, түүвэр судалгаа, олон нийтийн зүгээс давтагдан гарч байгаа санал, шүүмжлэл зэргийг ашиглана.

21. Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх ажилд тухайн асуудлаас хамааруулан холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, холбогдох бусад талуудыг оролцуулна.

22. Төслийн нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх болон төслийг боловсруулах явцад тухайн асуудалтай холбоотой мэдээллийг бусад хүчин төгөлдөр бодлогын баримт бичиг, судалгаа, мэдээллээс иш татсан тохиолдолд бодлогын баримт бичиг болон судалгаа, мэдээллийн эх сурвалжийг заана.

23. Нөхцөл байдлын дүн шинжилгээ нь тухайн асуудлаар хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах үндэслэл, шаардлагыг гаргасан тулгамдсан асуудлыг мэдэрч тодорхойлсон баримт бичиг байна.

Тав. Нөлөөллийн урьдчилсан үнэлгээ

24. Нөлөөллийн урьдчилсан үнэлгээг төсөл санаачлан боловсруулж байгаа захиргааны байгууллага хариуцан гүйцэтгэж, уг үнэлгээний дүгнэлтийг төсөлд тусгасан байна.

25. Эдийн засаг, нийгэм, эсхүл тодорхой зорилтот бүлэгт урт, дунд хугацаанд тулгамдаж байгаа зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай ажил, үйлчилгээтэй холбоотой асуудлын эдийн засаг, нийгэм, байгаль орчин болон санхүүгийн салбарт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөө нь их гэж үзсэн тохиолдолд нөлөөллийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

26. Нөлөөллийн урьдчилсан үнэлгээг өмнө хийсэн судалгаа, үнэлгээ, албан ёсны тоон болон чанарын мэдээлэлд үндэслэн хийнэ.

Зургаа. Олон нийтээр хэлэлцүүлэх

27. Төслийг боловсруулахдаа Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 19.2-т заасны дагуу хэлэлцүүлэг зохион байгуулна.

28. Хэлэлцүүлэг болохоос 5-аас доошгүй өдрийн өмнө төслийг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр хэлэлцүүлэгт оролцогчдод хүргүүлнэ.



29. Төслийн талаар хувь хүн, хуулийн этгээд, төрийн байгууллага, холбогдох байгууллага, мэргэжлийн холбоодоос бичгээр болон цахим хэлбэрээр санал авч болно.

30. Энэ журмын 29-т заасан саналд дүн шинжилгээ хийж, шаардлагатай гэж үзвэл төсөлд тусгана.

Долоо. Зөвшөөрөл авах

31. Төрийн захиргааны төв байгууллага нь төрөөс баримтлах бодлогын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авна. Санал авахаар бодлогын баримт бичгийг хүргүүлэхдээ дараах мэдээллийг хавсаргасан байна:

31.1. нөхцөл байдлын дүн шинжилгээ;

31.2. энэхүү журмын 1 дүгээр хавсралтын дагуу боловсруулсан хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн зорилго, зорилтын уялдаа;

31.3. энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан хөгжлийн бодлогын баримт бичгийн хувилбар бүрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийн төсөөлөл тооцоо;

31.4. энэхүү журмын 3 дугаар хавсралтад заасан төслийг нийтээр хэлэлцүүлсэн хэлэлцүүлгийн явцад гарсан саналуудыг багцалсан товъёог;

31.5. энэхүү журмын 4 дүгээр хавсралтын дагуу боловсруулсан нөлөөллийн урьдчилсан үнэлгээ, түүгээр бодлогын хувилбаруудыг харьцуулан үнэлсэн тухай товч мэдээлэл;

31.6. энэхүү журмын 5 дугаар хавсралтын дагуу боловсруулсан хөгжлийн бодлогын баримт бичгийн шалгуур үзүүлэлт;

31.7. энэхүү журмын 6 дугаар хавсралтад заасан бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө.

32. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төслийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт энэ журмын 31.1-31.7-д заасан мэдээллийн хамт хүргүүлнэ.

33. Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын төслийг Засаг дарга иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр Хурлын ажлын албанд энэ журмын 31.1-31.7-д заасан мэдээллийн хамт хүргүүлнэ.



34. Төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийн төсөл нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 5.1-д заасан зарчим, мөн хуулийн 17.2-т заасан шаардлага, энэхүү журамд заасан бүрдэл материал дутуу тохиолдолд уг зарчим, шаардлага болон бүрдлийг хангуулах талаарх зөвлөмжийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь холбогдох төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

Найм. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөл боловсруулах

35. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нэгтгэн боловсруулж, зохих журмын дагуу хэлэлцүүлнэ.

36. Захиргааны байгууллага нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлогын зорилго, зорилтуудыг үндэслэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулах өөрийн хариуцсан асуудлын хүрэн дэх бодлогын тэргүүлэх зорилтын талаарх саналыг чиглэл болгосон хугацаанд багтаан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

37. Захиргааны байгууллага нь энэ журмын 35-д заасан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулах өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хамаарах 3 хүртэлх тооны бодлогын тэргүүлэх зорилтыг тодорхойлсон байна.

38. Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн захиргааны байгууллага Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулах бодлогын тэргүүлэх зорилтын талаарх саналыг чиглэл болгосон хугацаанд багтаан Ерөнхий сайд, Монгол Улсын Шадар сайдад хүргүүлнэ.

39. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг нэгтгэн хянан боловсруулж зохих журмын дагуу Засгийн газраар батлуулна.

40. Захиргааны байгууллага нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгуулах саналыг Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийн нэрсийн жагсаалтын хамт Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсанаас хойш 30 хоногийн дотор боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.



41. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хамт Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үндэсний хөтөлбөрийн жагсаалтыг боловсруулна.

42. Захиргааны байгууллага нь үндэсний хөтөлбөрийн жагсаалтыг шинээр боловсруулах, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх гэж ангилан, ач холбогдлоор нь эрэмбэлсэн байна.

43. Үндэсний хөтөлбөрийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг авахдаа баримт бичгийн төслийг энэ журмын 31.1-31.7-д заасан мэдээллийн хамт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Ес. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн
төсөл, дэд хөтөлбөрийн жагсаалтын
төслийг боловсруулах

44. Засаг дарга нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15.2-т заасны дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг дэд хөтөлбөрийн жагсаалтын хамт боловсруулна.

45. Дэд хөтөлбөрийн жагсаалтыг шинээр боловсруулах, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх гэж ангилан, ач холбогдлоор нь эрэмбэлсэн байна.

46. Шинээр боловсруулах дэд хөтөлбөрийн төслийг Засаг дарга боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр Хурлын ажлын албанд энэ журмын 31.1-31.7-д заасан мэдээллийн хамт хүргүүлнэ.

Арав. Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн
чиглэлийн төслийг боловсруулах

47. Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 12.3, 12.4, 12.6, 12.7-д заасан цаглабарын дагуу боловсруулна.

48. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг дараах шаардлагын хүрээнд нэгтгэн боловсруулна:

48.1. үндсэн чиглэлийн төсөлд тусгасан арга хэмжээ нь тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай байх;



48.2. энэхүү журмын 7 дугаар хавсралтын хүснэгт 1-д заасны дагуу арга хэмжээ бүрт шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр нь үндэслэлтэй, бодитой, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн байх;

48.3. үндсэн чиглэлийн төсөлд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг өөрчлөх тохиолдолд тухайн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох төрийн захиргааны байгууллагатай харилцан зөвшилцөнө.

49. Захиргааны байгууллага нь улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд тусгуулах саналаа Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон үндэсний хөтөлбөрийн тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээг үндэслэн боловсруулж Сангийн яаманд заасан хугацаанд хүргүүлнэ.

50. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төрийн захиргааны төв, холбогдох төрийн захиргааны байгууллагаас үндсэн чиглэлийн төсөлд тусгуулахаар хүргүүлсэн саналыг хянаад төсөлд тусгасан, эсхүл тусгаагүй тухай үндэслэл, тайлбарыг энэхүү журмын 7 дугаар хавсралтын хүснэгт 2-т заасны дагуу боловсруулж, төрийн захиргааны төв болон холбогдох төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

Арван нэг. Төслийн бүтэц, агуулга

51. Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын төсөл нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 4.1.7, 7 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

52. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6.3, 6.4.3-т заасан төсөл дараах ерөнхий бүтэц, агуулгатай байна:

52.1. нэгдүгээр бүлэг. Ерөнхий мэдээлэл;

52.2. хоёрдугаар бүлэг. Бодлогын зорилго, зорилт;

52.3. гуравдугаар бүлэг. Бодлогын хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагаа;

52.4. дөрөвдүгээр бүлэг. Бодлогын үр нөлөө, бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлт;

52.5. тавдугаар бүлэг. Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр;

52.6. зургаадугаар бүлэг. Бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө.

53. Энэхүү журмын 52.1-д заасан “Ерөнхий мэдээлэл” бүлэгт дараах зүйлийг тусгасан байна:

53.1. тулгамдаж байгаа асуудал, нөхцөл байдлын дүн шинжилгээний гол үр дүн;

53.2. бодлогын төслийг боловсруулах үндэслэл;

53.3. төслийн хамрах хүрээ.

54. Энэхүү журмын 52.2-т заасан “Бодлогын зорилго, зорилт” бүлэгт дараах асуудлыг тусгасан байна:

54.1. бодлогын зорилго, зорилт нь тухайн бодлогыг хэрэгжүүлснээр урт, дунд хугацаанд нийгэм, эдийн засгийн хөгжилд бий болохоор хүлээгдэж байгаа өөрчлөлтийг илэрхийлсэн бодлогын үр нөлөөнд тулгуурласан тодорхой, хэмжиж болохуйц, хүрч болохуйц, хэрэгжихүйц бодитой байна;

54.2. бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хугацааг тодорхойлсон байна;

54.3. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6.3-т заасан хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөлд Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын тодорхой зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн тэргүүлэх болон нэмэлт зорилтуудыг тодорхойлсон байна.

54.4. үндэсний хөтөлбөрийн төсөлд төрөөс баримтлах бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн төсөлд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тодорхой зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн тэргүүлэх болон нэмэлт зорилтуудыг тус тус тодорхойлсон байна.

55. Төслийн зорилго, зорилт нь дараах уялдааг хангасан байна:

55.1. төрөөс баримтлах бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлогын зорилго нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын зорилтод үндэслэх;

55.2. аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтын зорилго нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, бүсчилсэн хөгжлийн бодлогын зорилтод үндэслэх;

55.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлого, бүсчилсэн хөгжлийн бодлогын зорилтод үндэслэх;



55.4. үндэсний хөтөлбөрийн зорилго нь төрөөс баримтлах бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтод үндэслэх;

55.5. улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх;

55.6. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилго нь аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтод үндэслэх;

55.7. дэд хөтөлбөрийн зорилго нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтод үндэслэх.

56. Энэхүү журмын 52.3-т заасан “Бодлогын хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагаа” бүлэгт бодлогыг хэрэгжүүлэх үе шат бүрт зорилт тус бүрээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлсон байна.

57. Энэхүү журмын 52.4-т заасан “Бодлогын үр нөлөө, бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлт” бүлэгт бодлогыг хэрэгжүүлсний үр дүнд бий болох бүтээгдэхүүн, үр нөлөө, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна.

58. Бодлогын үр нөлөө, бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлтийг бусад бодлогын баримт бичиг, статистикийн мэдээ, салбарын мэдээлэлд үндэслэн дараах байдлаар тодорхойлно:

58.1. бодлогын зорилго, зорилт бүрийг хэрэгжүүлсний үр дүнд бий болох эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг тодорхойлох;

58.2. зорилт тус бүрийн хүрээнд 2-5 хүртэлх тооны эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг тодорхойлж, тухайн үр нөлөө бүрт 2-оос доошгүй шалгуур үзүүлэлтийг тодорхойлох;

58.3. бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагаас бусад этгээдэд хүргэх эцсийн бүтээгдэхүүнийг завсрын бараа, ажил, үйлчилгээ буюу эцсийн бүтээгдэхүүнийг бий болгоход ашиглагдах бүтээгдэхүүнээс ялгаж тодорхойлох;

58.4. бодлогын бүтээгдэхүүн бүрт 1-ээс доошгүй шалгуур үзүүлэлтийг тодорхойлох;

58.5. төсөлд шалгуур үзүүлэлтийн суурь түвшин, суурь он, зорилтот түвшин болон он, мэдээллийн эх сурвалжийг тодорхойлсон байх бөгөөд шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар илэрхийлнэ:

58.5.1. бодлогыг хэрэгжүүлсний үр дүнд гарах өөрчлөлт нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын зорилт, шалгуур үзүүлэлттэй уялдсан байдал;

58.5.2. бодлогын хэрэгжилтийг үнэлэх бусад шалгуур үзүүлэлт.

59. Энэхүү журмын 52.5-д заасан “Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр” бүлэгт дунд хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөлд тусгагдсан зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг бодлогын зорилт тус бүрээр макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, гадаад өрийн зохистой харьцаа, төсвийн хүрээний мэдэгдэл болон улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт үндэслэсэн тооцооны хамт тусгасан байна:

60. Энэ журмын 52.6-д заасан “Бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө” бүлэгт дараах зүйлийг тусгасан байна:

60.1. хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх байгууллага, нэгтгэн тайлагнах хугацаа;

60.2. хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн, санал зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаа.

61. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөл дараах ерөнхий бүтэц, агуулгатай байж болно:

61.1. нэгдүгээр бүлэг. Ерөнхий мэдээлэл;

61.2. хоёрдугаар бүлэг. Эдийн засгийн хөгжлийн бодлогын зорилго, тэргүүлэх зорилтууд;

61.3. гуравдугаар бүлэг. Нийгмийн хөгжлийн бодлогын зорилго, тэргүүлэх зорилтууд;

61.4. дөрөвдүгээр бүлэг. Байгаль орчны бодлогын зорилго, тэргүүлэх зорилтууд;

61.5. тавдугаар бүлэг. Засаглалын бодлогын зорилго, тэргүүлэх зорилтууд;



61.6. зургадугаар бүлэг. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ.

62. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг энэхүү журмын 8 дугаар хавсралтад заасан хүснэгтийн дагуу боловсруулна.

63. Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийн салбарын танилцуулга бүлэгт тухайн салбарт дунд, богино хугацаанд тулгарч байгаа асуудал, нөхцөл байдлын дүн шинжилгээ, өмнөх оны үндсэн чиглэлийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг тусгасан байна.

64. Үндсэн чиглэлийн төсөлд тусгах арга хэмжээг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээ болон нутгийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн санал, төсвийн хязгаарт үндэслэн энэхүү журмын 7 дугаар хавсралтын хүснэгт 1-д нийцүүлэн боловсруулна.

65. Нутгийн захиргааны байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулахдаа энэхүү журмын 65, 66-д заасныг баримтална.

Арван хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний уялдаа

66. Дунд хугацааны бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд үндэслэн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийг эрх бүхий байгууллага гаргана.

67. Урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр нөлөөний талаар бодлого боловсруулагчид болон нийтэд мэдээлэхдээ хөндлөнгийн үнэлгээний тайланд үндэслэнэ.

68. Төслийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтийг боловсруулахдаа өмнө нь хэрэгжүүлсэн хөгжлийн бодлогын баримт бичгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ болон хөндлөнгийн үнэлгээний тайланг харгалзана.

69. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр тухайн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх хугацааны эхний хагаст шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшний 30 хүртэлх хувийг хангаагүй нь тогтоогдсон тохиолдолд уг бодлогыг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх эсэхийг тухайн бодлогын баримт бичгийг баталсан эрх бүхий этгээд шийдвэрлэнэ.

Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах
нийтлэг журмын 1 дүгээр хавсралт

ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДИЙН УЯЛДАА
(бодлогын хувилбар бүрээр)

№	Боловсруулж байгаа бодлогын баримт бичгийн зорилго, зорилт	Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал	Төрөөс баримтлах бодлого	Бүсчилсэн хөгжлийн бодлого (Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал)	Бусад бодлогын баримт бичиг
1		Нийцэж байгаа зорилго, зорилт	Нийцэж байгаа зорилго, зорилт	Нийцэж байгаа зорилго, зорилт	Нийцэж байгаа зорилго, зорилт
2					
3					
4					
...					
Нийт					
Нийцсэн* (тоо, %)					

Тайлбар танилцуулга:
(Энэ хэсэгт хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл нь бусад бодлогын зорилго, зорилттой хэрхэн уялдаж байгаа талаар товч танилцуулга бичнэ)



ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХУВИЛБАР БҮРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД
ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ
ҮҮСВЭРИЙН ТӨСӨӨЛӨЛ ТООЦОО (хувилбар бүрээр)
(сая төгрөгөөр)

№	Бодлогын зорилго, зорилт	Эхлэх/ дуусах огноо	Нийт (1+2+...+k)	Төсвийн жил 1 (1)			Төсвийн жил 2 (2)			Төсвийн жил k (k)			
				Нийт шаардагдах санхүүжилт	Урсгал зардал	Хөрөнгө оруулалт	Нийт шаардагдах санхүүжилт	Урсгал зардал	Хөрөнгө оруулалт	Нийт шаардагдах санхүүжилт	Урсгал зардал	Хөрөнгө оруулалт	
1	Зорилго 1												
1.1.	Зорилт 1												
1.2.	Зорилт 2												
...	...												
	Нийт шаардагдах хөрөнгийн хэмжээ												
	Санхүүжилтийн эх үүсвэр												
	Улсын төсөв												
	Орон нутгийн төсөв												
	Гадаадын зээл, тусламж												
	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт												
	Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас												
	Концессын гэрээ												
	Бусад эх үүсвэр												



Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах
нийтлэг журмын 3 дугаар хавсралт

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН САНАЛЫН БАГЦ ТОВЬЁОГ

№	Бодлогын баримт бичгийн холбогдох зорилго, зорилт	Байгууллага, хувь хүн	Санал гаргасан			Тусгасан эсэх (Тайлбар, үндэслэл)
			Нэмэлт оруулах	Хасах	Өөрчлөх	
1						
2						
3						
...						

Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах
нийтлэг журмын 4 дүгээр хавсралт

**БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН НӨЛӨӨЛЛИЙН
УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭ**

<p>А. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр эдийн засгийн хөгжил, захиргааны үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөл</p>	
<p>1. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр нөлөө үзүүлэх зорилтот бүлэг болон бусад бүлэг</p>	<p>Бодлогыг хэрэгжүүлснээр хууль ёсны эрх ашиг, санхүүгийн боломж, өнөөгийн нөхцөл байдал нь шууд болон шууд бусаар нөлөөлж байгаа нийгмийн зорилтот бүлгийг тодорхойлно. Зорилтот бүлэг гэж бүлэг хувь хүмүүс, нийгмийн бүлэг, хуулийн этгээд (Засгийн газрын болон орон нутгийн удирдлагын байгууллага, түүний ажилчид) зэрэг тухайн бодлогыг хэрэгжүүлснээр эерэг болон сөрөг нөлөө хүртэх бүлгийг хэлнэ.</p>



<p>2. Эдийн засгийн хөгжил болон захиргааны үйл ажиллагаанд үзүүлэх нөлөө</p>	<p>1. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын шалгуур үзүүлэлтэд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох 2. Захиргааны үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг урьдчилан тооцоолох: 2.1. захиргааны үйл ажиллагааны нөлөө хэвээр үлдэж байгаа бол бодлогын хэрэгжилт, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь зорилтот бүлгийн эрх ашиг, харилцаагйг хөндөхгүй гэдгийг тодорхойлон бичиж; 2.2. захиргааны үйл ажиллагааны нөлөө буурч байгаа бол бодлогын хэрэгжилт, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнээс үр шим хүртэж байгаа нийгмийн бүлэг, байгууллага, аж ахуй, салбарыг тодорхойлон бичиж; 2.3. захиргааны үйл ажиллагааны нөлөө нэмэгдэж байгаа бол бодлогын хэрэгжилт, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь нийгмийн ямар бүлэг, байгууллага, аж ахуй, салбарт үзүүлж байгаа ямар гол өөрчлөлтүүд бий болж байгааг тодорхойлон бичиж.</p>
<p>3. Бусад мэдээлэл</p>	<p>Энэхүү нөлөөллийн үнэлгээний "А"-гийн 1, 2 дахь хэсэгт дурдаагүй эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөллийн талаар энд бичиж болно.</p>
	<p>Б. Хөгжлийн бодлогын баримт бичгийн нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл</p> <p>1. Бодлогын баримт бичгийн төсөл нь хэд хэдэн нийгмийн бүлэгт нөлөө үзүүлэхээр байгаа бол тус бүрээр нь тодорхойлно. Мэдээлэл нь тодорхой бүлэгт үзүүлэх нөлөөллийн хэмжээ, нөлөөлөх магадлал, үр дүнгийн талаар байна. Асуудал болон бодлогын хувилбарууд аль бүлэгт хамааралтай болохыг тодорхойлно. Тухайлбал, орон нутгийн захиргааны байгууллага, Засгийн газар, жижиг, дунд, том бизнес эрхлэгчид, импортлогчид, экспортлогчид, дотоодын зах зээлд бүтээгдэхүүн ханган нийлүүлэгчид, хэрэглэгчид, газар зүйн бүсүүд, нийгмийн бүлгүүд байна. Нийгэмд үзүүлэх нөлөөлөл нь шилжилтийн байх, эсхүл урт хугацааны байх гэдгийг тодорхойлно. Түүнчлэн нийгэмд үзүүлэх нөлөөлөлд ямар эрсдэл учирч болох, түүнийг хэрхэн даван туулах талаар мэдээлсэн байна.</p> <p>2. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр ямар нөлөө үзүүлэхийг дараах байдлаар тодорхойлсон байна: 2.1. хүмүүсийн амьдралын хэв маягт үзүүлэх нөлөөний талаар; 2.2. хүмүүсийн соёлд ямар нөлөө үзүүлэх (хамтын итгэл, зан үйл, үнэт зүйл, соёл гэх мэт); 2.3. хүмүүсийн амьдардаг суурин болон нийгмийн бүлэгт ямар нөлөө үзүүлэх (ялдаа, тогтвортой байдал, шинж чанар, үйлчилгээ, байгууламж); 2.4. хүрээлэн буй орчинд ямар нөлөө үзүүлэх (хүмүүсийн хэрэглэдэг ус, амьсгалдаг агаарын чанар, хүнсний бүтээгдэхүүний чанар, огдоц, аюул, эрсдэлийн түвшин, тоос, дуу чимээний хэмжээ, ариун цэврийн байгууламжийн хангамж, байгууламжийн аюулгүй байдал, нөөцөөс хүртэх боломж, нөөцөд хяналт тавих боломж).</p>
<p>3. Бусад мэдээлэл</p>	<p>Энэхүү нөлөөллийн үнэлгээний "Б"-гийн 1, 2 дахь хэсэгт дурдаагүй нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөөллийн талаар энд бичиж болно.</p>
	<p>В. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж болон эрх зүйн тогтолцоонд үзүүлэх нөлөө</p>
<p>1. Бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль, эрх зүйн акт</p>	<p>Тухайн бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай Улсын Их Хурлаар батлагдах, эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомж, дүрэм, журам, тэдгээрийн хэрэгцээ, шаардлага, агуулгын талаар жагсаан бичнэ.</p>
<p>2. Харилцаах байгууллага</p>	<p>Энэхүү нөлөөллийн үнэлгээний "В"-д дурдсан хууль, эрх зүйн актад нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг хариуцсан байгууллагын талаарх мэдээллийг энд бичнэ.</p>

Г. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлснээр одоогийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын (институцийн) тогтолцоонд үзүүлэх нөлөө	
1. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд оролцох байгууллагууд	Хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох эрх бүхий бүх байгууллага, хуулийн этгээдийг тодорхойлж, хэрэгжилтийн аль үе шатанд оролцох талаар бичнэ.
2. Төрийн удирдлагын үйл ажиллагаа, бүтцэд үзүүлэх нөлөө (шинээр бүтээх бий болох, өнөөгийн институцийг татан буулгах, эсхүл бүтцийг өөрчлөн байгуулах)	1. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд шинээр байгууллага бий болгох шаардлагатай тохиолдолд одоо байгаа байгууллагын бүтцээр бодлогыг хэрэгжүүлж болохгүй байгаа шалтгааныг бичнэ. 2. Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх явцад аливаа нэгэн байгууллагыг татан буулгах шаардлагатай тохиолдолд цаашид энэхүү байгууллагын чиг үүргийг хэрхэн үргэлжлүүлэх талаар тайлбарлан бичнэ. 3. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад аливаа нэгэн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх шаардлагатай тохиолдолд тус байгууллагын чиг үүрэг хэрхэн өөрчлөгдөх, тодорхой чиг үүргийг тухайлбал, бүс, орон нутгийн байгууллага болон хувийн хэвшлээр гүйцэтгүүлж болохгүй талаар тайлбарлан бичнэ. 4. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх боломжийг судалж бичнэ. 5. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжүүлэх боломжийг судалж бичнэ.
3. Хүний нөөцөд үзүүлэх нөлөө	Хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагын хүний нөөц, чадавхид өөрчлөлт оруулахгүйгээр бодлогыг хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар бичнэ.

Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах
нийтлэг журмын 5 дугаар хавсралт

ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮСНЭГТ

№	Бодлогын баримт бичгийн бүлэг/ заалт	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин		Хэрэгжүүлэх байгууллагууд*
					Он	Үзүүлэлт	Он	Үзүүлэлт	
					Он	Үзүүлэлт	Он	Үзүүлэлт	

1. Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын зорилт, шалгуур үзүүлэлт (он/зорилтот түвшин) (энэ хэсэгт зөвхөн Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалтай уялдсан шалгуур үзүүлэлтүүдийг тусгана)	
1	
2	
3	
...	
2. Бодлогын баримт бичгийн үр дүнг үнэлэх бусад шалгуур үзүүлэлтүүд	
1	
2	
3	
...	

*-хэрэгжүүлэх байгууллагуудыг хэрэгжилтийг хангах хариуцлагын эрэмбээр жагсаана.
Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 6 дугаар хавсралт

**ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО, ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАГВАР**

Зорилго	Бодлого, хөтөлбөрийн зорилго			
Үр нөлөө (үр нөлөөний шалгуур үзүүлэлт)	Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан үр нөлөөг бичнэ. Түүнчлэн хэрэгжилтийн үр дүнг үнэлэхэд ашиглах үр нөлөөний шалгуур үзүүлэлтийг бичнэ.			
1. Үйл ажиллагааны чиглэл	Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан болон шинэ үйл ажиллагааны чиглэл			
№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хармуцах байгууллага Хамтран хэрэгжүүлэх байгууллага Хэрэгжих хугацаа
	Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилт 1			

Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилт 2				
Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан болон шинэ үйл ажиллагааны чиглэл				
№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хармуцах байгууллага Хамтран хэрэгжүүлэх байгууллага Хэрэгжих хугацаа
Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилт 1				

Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 7 дугаар хавсралт

Хүснэгт 1. ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮСНЭГТ

№	Дунд хугацааны бодлогын баримт бичиг	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Шаардлагатай хөрөнгийн хэмжээ, хөрөнгийн эх үүсвэр	Хариуцах байгууллага
1	2	3	4	5	6	7
Зорилт 1.						
1.1						



Хүснэгт 2. Үндсэн чиглэлийн төсөлд ирүүлсэн саналуудын тайлбар товчоог

№	Төрийн захиргааны төв, төрийн захиргааны байгууллага	Арга хэмжээ	Дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдсан эсэх	Үндсэн чиглэлд туссан эсэх	Тусгааргүй арга хэмжээний тайлбар	Төлөвлөгдсөн санхүүжилт (төлөвлөсөн/баталсан)	Батлагдсан санхүүжилтийн хувь
1	Зам, тээврийн яам	Арга хэмжээ 1					
2		Арга хэмжээ 2					
3		Арга хэмжээ 3					
...							

Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах
нийтлэг журмын 8 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ... ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

ЗГЛАХ-т тусгагдсан зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэглэх хугацаа	Нийт хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрэх түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр)						Хэрэгжүүлэх байгууллага		
				2017 он		2018 он		2019 он			2020 он	
				Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв		Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв
ХӨГЖИЙН САЛБАР №1.1. ХӨДӨӨ АЖ АХҮЙ												
Зорилто №1.1.1. Бэлчээрийн малын удмын санг хадгалж, сургийн бүтцийн зохистой харьцааг бүрдүүлж, малын эрүүл мэнд, эрсдэл даах чадварыг сайжруулах, мал амьтны эрүүл мэндийн хяналт, үйлчилгээнд олон улсын стандартыг үе шаттайгаар нэвтрүүлэн, хөдөө аж ахуйн бүтээмжийг нэмэгдүүлэн олон улсын зах зээлд гаргана.												



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 5 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 261

Улаанбаатар
хот

Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого батлах тухай

Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг хэрэгжүүлэх зорилгоор Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 8.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-ыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэд, хэрэгжилтийг эрхэлсэн салбар, харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-ын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд, хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тус тус тусгаж, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, хандив, тусламжид хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Болор, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

**ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

С.ЭРДЭНЭ

ТӨРӨӨС ХҮН АМЫН ХӨГЖЛИЙН ТАЛААР
БАРИМТЛАХ БОДЛОГО
(2016-2025 он)

Нэг. Бодлогын зорилго

1.1. Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын зорилго нь хүн амын тогтвортой өсөлтийг хангах, иргэдийн урт удаан, эрүүл энх, бүтээлчээр амьдрах, хөгжих таатай орчныг бүрдүүлэх, хувь хүн болон гэр бүлийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршино.

Хоёр. Бодлогыг хэрэгжүүлэх зарчим

2.1. Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд дараах үндсэн зарчмыг баримтална:

2.1.1. хүний хөгжлийг улс орны хөгжил, дэвшлийн үндэс гэж үзэх;

2.1.2. хүний эрхэд суурилсан хөгжлийн чиг хандлагыг баримталж, хүний амьдрах орчин, амьжиргааны эх үүсвэрийг хамгаалах тогтвортой, ногоон хөгжлийг эрхэмлэх;

2.1.3. хүнийг үндэс угсаа, арьс өнгө, нас, хүйс, шашин шүтлэг, нутаг ус, нийгмийн болон эрүүл мэндийн байдал, бэлгийн чиг хандлагаар үл ялгаварлах;

2.1.4. үндэсний өв соёл, зан заншлыг дээдлэх;

2.1.5. бүх салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах;

2.1.6. төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, орон нутгийн иргэд, хамт олны оролцоонд тулгуурлах.

Гурав. Бодлогыг хэрэгжүүлэх чиглэл,
хүрэх үр дүн

3.1. Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ:

3.1.1. хүн амын тогтвортой өсөлтийг хангах таатай нөхцөлийг бүрдүүлэх;

3.1.2. хүн амын шилжилт хөдөлгөөнийг зохистой түвшинд байлгах;



3.1.3. гэр бүлийн амьдралын таатай орчныг бүрдүүлэх, амьдралын чанарыг сайжруулах;

3.1.4. хүн бүр боловсрол эзэмших, хөгжих боломжийг бүрдүүлэх;

3.1.5. хүн амыг ажилтай, орлоготой байх нөхцөлийг бий болгох;

3.1.6. хүн амын эрүүл, идэвхтэй насжилтыг дэмжих.

3.2. Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

3.2.1. “хүн амын тогтвортой өсөлтийг хангах таатай нөхцөлийг бүрдүүлэх” чиглэлийн хүрээнд хүн амын дундаж наслалтыг 74-т хүргэх, төрөлтийн түвшинг эргэн нөхөгдөх түвшинд буюу түүнээс дээш түвшинд байлгах замаар хүн амын тогтвортой өсөлтийг хангана;

3.2.2. “хүн амын шилжилт хөдөлгөөнийг зохистой түвшинд байлгах” чиглэлийн хүрээнд орон нутагт хүн тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлж, хөдөө рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг урамшуулах замаар хөдөөгийн хүн амын нийт хүн амд эзлэх хувийг нэмэгдүүлж, хүн амын байршлын зохистой харьцааг хот, хөдөөд тэнцвэртэй болгоно;

3.2.3. “гэр бүлийн амьдралын таатай орчныг бүрдүүлэх, амьдралын чанарыг сайжруулах” чиглэлийн хүрээнд иргэдэд гэр бүлийн боловсролыг хүүхэд наснаас олгох, гэр бүлийн тогтвортой харилцааг дэмжиж, амьжиргааны тогтвортой эх үүсвэртэй болгох арга хэмжээг авах замаар гэр бүлийг дэмжиж, нийгмийн дундаж давхаргыг нийт хүн амын 60 хувьд хүргэнэ;

3.2.4. “хүн бүр боловсрол эзэмших, хөгжих боломжийг бүрдүүлэх” чиглэлийн хүрээнд хүн авьяас чадвараа хөгжүүлэн үр бүтээлтэй хөдөлмөрлөж, аз жаргалтай амьдрахад шаардагдах чанартай боловсрол, мэдлэг, чадварыг эзэмших, зөв төлөвших, насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлж, тэмүүлэлтэй, хариуцлагатай, бүтээлч, хөдөлмөрч, бусдыг хүндлэх хүмүүнлэг ёс зүйтэй, амьдралын зөв дадал, хэвшилтэй, үндэсний дэвшилтэт уламжлал, өв соёлоо дээдэлсэн монгол хүнийг төлөвшүүлнэ;

3.2.5. “хүн амыг ажилтай, орлоготой байх нөхцөлийг бий болгох” чиглэлийн хүрээнд эдийн засгийн өсөлтийн өгөөжийг зохистой хуваарилж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажиллах хүчний нөөцийг төлөвлөлттэйгээр үр дүнтэй ашиглах замаар хүн амыг ажилтай, орлоготой болгож, ажилгүйдлийн түвшинг 4 хувьд, ядуурлын түвшинг нэг оронтой тоонд хүртэл бууруулна;

3.2.6 “хүн амын эрүүл, идэвхтэй насжилтыг дэмжих” чиглэлийн хүрээнд нийгмийн хамгааллын тогтолцоог боловсронгуй болгож, эдийн



засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдах хувийг 95-д хүргэх бөгөөд ахмад настны нийгмийн баталгааг хангах, нийгмийн идэвхтэй гишүүн байх, боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.

3.3. Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн явцыг дараах үзүүлэлтээр тодорхойлж, үр дүнг үнэлнэ:

№	Бодлогын чиглэл	Үр дүнгийн үндсэн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2015)	Зорилтот түвшин			
					2020	2025		
1	Хүн амын тогтвортой өсөлтийг хангах таатай нөхцөлийг бүрдүүлэх	1	Хүн амын жилийн дундаж өсөлт	хувь	2.1	≥2.1	≥2.1	
		2	Төрөлтийн нийлбэр коэффициент	хүүхдийн тоо	3.0	≥3.0	≥3.0	
		3	Дундаж наслалт	Нийт	жил	69.9	72.2	74
				Эрэгтэй	жил	66.0	68	70
				Эмэгтэй	жил	75.8	77.5	78.4
		4	Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлт тутамд)	промилль	26	25	20	
5	Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	промилль	15	13	11			
6	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	промилль	18	15	12			
2	Хүн амын шилжилт хөдөлгөөнийг зохистой түвшинд байлгах	7	Нийт хүн амд хөдөөгийн хүн амын эзлэх хувь	хувь	32.0	38.0	50.0	
3	Гэр бүлийн амьдралын таатай орчныг бүрдүүлэх, амьдралын чанарыг сайжруулах	8	Нийгмийн дундаж болон чинээлэг дундаж давхаргын нийт хүн амд эзлэх хувь ¹	хувь	36.7	45	60	
4	Хүн бүр боловсрол эзэмших, хөгжих боломжийг бүрдүүлэх	9	Сургуулийн өмнөх насны хүүхдийн боловсролын үйлчилгээнд хамрагдах хувь ²	хувь	68.5	70	80	
		10	Хүний хөгжлийн индекс	эзлэх байр	90	85	80	
5	Хүн амыг ажилтай, орлоготой байх нөхцөлийг бий болгох	11	Хөдөлмөрийн насны хүн амд эдийн засгийн идэвхтэй хүн амын эзлэх хувь	хувь	61.5	66	68	
		12	Ажилгүйдлийн түвшин	хувь	7.5	6.0	4.0	
		13	Ядуурлын түвшин	хувь	21.6	18.0	9.0	
		14	Орлогын тэгш бус байдлын үзүүлэлт ³	оноо	32.0	31.5	31.0	
6	Хүн амын эрүүл, идэвхтэй насжилтыг дэмжих	15	Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдалтын хувь	хувь	79.5	90.0	95.0	

¹ Нэг хүнд ногдох дундаж хэрэглээнээс дээш хэрэглээтэй хүн амын эзлэх хувь

² Цэцэрлэг, хувилбарт сургалтад хамрагдсан 2-5 насны хүүхдийн 2-5 насны нийт хүн амд эзлэх хувь

³ Жини коэффициент



Дөрөв. Бодлогын зорилт

4.1. “Хүн амын тогтвортой өсөлтийг хангах таатай нөхцөлийг бүрдүүлэх” чиглэлээр дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

4.1.1. нөхөн үржихүйн насны болон жирэмсэн эмэгтэйчүүд, эх, нярайд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хүртээмж, чанар, аюулгүй байдлыг сайжруулах;

4.1.2. жирэмсэн эмэгтэйчүүд, эх, нярайд үзүүлэх нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах, нэмэгдүүлэх;

4.1.3. эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх, сэргийлж болох хүчин зүйлийг багасгах замаар эхийн эндэгдлийн харьцааг 100000 амьд төрөлтөд 20, тав хүртэл насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 12, нялхсын эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 11 болгож бууруулах;

4.1.4. өсвөр үе, залуучуудад нөхөн үржихүй, бэлгийн эрүүл мэндийн цогц боловсролыг олгож, өсвөр насны охидыг хүсээгүй жирэмслэлт, эрт төрөлт, үр хөндөлтөөс сэргийлэх;

4.1.5. гэр бүл, эмэгтэйчүүдийг хүүхдийн тоо, төрөлт хоорондын зайг өөрсдөө зохицуулах нөхөн үржихүйн эрхийг хангасан гэр бүл төлөвлөлтийн чанартай, хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр хангах;

4.1.6. хүн амыг бэлгийн замаар дамжих халдвар, хүний дархлал хомсдлын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолын хам шинж өвчнөөс урьдчилан сэргийлэх, халдварын тархалтыг тогтвортой бууруулах;

4.1.7. хүн амд эрүүл мэндийн боловсрол олгож, эрүүл мэндээ хамгаалах, амьдралын эрүүл, зөв хэв маяг, зан үйлийг төлөвшүүлэх;

4.1.8. нийтийн биеийн тамир, спортыг дэмжин дэлгэрүүлж, иргэд өөрийн сонирхол, хэрэгцээ, шаардлагад тохируулж зөв хичээллэх мэдлэг, чадварыг эзэмшүүлэх, биеийн тамир, спортоор хичээллэх эрүүл, аюулгүй орчин, нөхцөлийг бүрдүүлэх;

4.1.9. хүн амын эрүүл, зохистой хооллолтыг дэмжих, хоол тэжээлийн хангамж, чанарыг сайжруулах, хүнсний аюулгүй байдлыг хангах, жирэмсэн эмэгтэйчүүд, эх, нярай, хүүхдийн хоол тэжээл, амин дэмийн дутлыг тогтвортой бууруулах;

4.1.10. хүний эрүүл мэнд, амьдралын чанарын түвшинд сөргөөр нөлөөлж байгаа агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх;

4.1.11. хүн амыг эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй анхан шатны тусламж, үйлчилгээгээр үнэ төлбөргүй, шуурхай хангах, эрүүл мэндийн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээг эх орондоо авах боломж, нөхцөлийг бүрдүүлэх;

4.1.12. халдварт болон халдварт бус өвчлөлд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, өвчлөлийг эрт илрүүлж, оношлох, тархалт, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бүрдүүлэн оношилгоо, эмчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн өвчлөл, нас баралтын эрсдэлт хүчин зүйлийг бууруулж, хүн амын дундаж наслалтыг 74-т хүргэх;

4.1.13. эрэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж, эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх;

4.1.14. хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг сайжруулж, осол, гэмтлийн улмаас нас барах явдлыг тогтвортой бууруулах, хүн амыг олдмол хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх;

4.1.15. хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настны эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлэх;

4.1.16. архидан согтуурах, мансуурах, донтохоос урьдчилан сэргийлэх, донтсон иргэдэд эрүүл мэнд, нийгмийн цогц үйлчилгээг тэгш, хүртээмжтэй үзүүлж, эрүүлжүүлж нийгэмшүүлэх.

4.2. “Хүн амын шилжилт хөдөлгөөнийг зохистой түвшинд байлгах” чиглэлээр дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

4.2.1. иргэдийн шилжилт хөдөлгөөний бүртгэл, мэдээллийг хүн ам, өрхийн мэдээллийн нэгдсэн сантай уялдуулах, гадаад шилжилт хөдөлгөөний бүртгэл, мэдээллийг сайжруулах;

4.2.2. хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоог бүрдүүлж, хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хот, суурин газар, орон нутгийн тогтвортой хөгжлийг газар зохион байгуулалт, хот байгуулалт, дэд бүтэц, аж үйлдвэр зэрэг бусад салбарын бодлоготой уялдуулах;

4.2.3. хот байгуулалтын ногоон хөгжлийн стандарт, олон улсын стандартад нийцсэн хот, суурин газрыг хөгжүүлж, иргэдийн эрүүл аюулгүй, тохилог амьдрах нөхцөлийг бүрдүүлэх;

4.2.4. малчин өрх, хот айл, жижиг, дунд тариалан эрхлэгчдийн аж ахуй эрхлэлтийг дэмжин орчин үеийн техник, технологи, эрчим хүчээр



хангаж, үйлдвэрлэл тогтвортой эрхлэх санхүү, эдийн засаг, эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэх;

4.2.5. нийгмийн суурь үйлчилгээний чанар, хүртээмжийг хот, хөдөөд жигд болгох;

4.2.6. байгаль, уур амьсгалын өөрчлөлт, гамшиг, зах зээлийн эрсдэлээс шалтгаалсан шилжилт хөдөлгөөнийг бууруулах, хүн амыг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даван туулах, зохицон амьдрах мэдлэг, чадвартай болгох;

4.2.7. нийслэл, хот, суурин газраас орон нутаг руу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөнийг урамшуулах;

4.2.8. ажиллах хүчний гадаад шилжилт хөдөлгөөнийг үндэсний эрх ашиг, хөгжлийн тэргүүлэх чиглэлд нийцүүлэн гадаад хамтын ажиллагаанд тулгуурлан зохицуулах нөхцөлийг бүрдүүлэх;

4.2.9. хилийн чанадад ажиллаж, амьдарч байгаа монгол иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, хүний наймаа, гэмт хэрэг, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлж, хохирогчийг хамгаалах;

4.2.10. гадаадад ажиллаж, амьдарч байгаа иргэдийг эх орондоо эргэн ирж амьдрахыг дэмжих.

4.3. “Гэр бүлийн амьдралын таатай орчныг бүрдүүлэх, амьдралын чанарыг сайжруулах” чиглэлээр дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

4.3.1. хүүхдэд бага наснаас нь эхлэн гэр бүлийн боловсрол олгох, ялангуяа өсвөр үе, залуучуудад гэр бүлийн амьдралд бэлтгэх, амьдралаа зөв авч явах, хариуцах чадварыг эзэмшүүлэх;

4.3.2. хүн амын удмын санд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, урьдчилан сэргийлэх, цус ойртолтыг үгүй болгох;

4.3.3. гэр бүлийн гишүүдийн тэгш эрх, үүрэг, хариуцлага, оролцоог хангах;

4.3.4. хүүхэд бүрийг гэр бүл, нийгмийн ээлтэй орчинд эсэн мэнд, аюулгүй, хүчирхийллээс ангид өсөх орчныг бүрдүүлэх;

4.3.5. гэр бүлийн харилцааны тогтвортой байдлыг дэмжих;

4.3.6. гэр бүлийг орон сууц, газар болон амьжиргааны олон талт эх үүсвэртэй болоход нь дэмжлэг үзүүлэх;

4.3.7. гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах, гэм буруутай этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх;

4.3.8. олон хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй болон өрх толгойлсон эцэг, эх бүхий гэр бүл, ганц бие ахмад настанд дэмжлэг үзүүлж амьдралын түвшинг дээшлүүлэх;

4.3.9. хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийгмийн үйлчилгээг хүртэх, гэр бүл, нийгмийн амьдралд идэвхтэй, тэгш оролцоход ээлтэй, хүртээмжтэй орчныг бий болгох.

4.4. “Хүн бүр боловсрол эзэмших, хөгжих боломжийг бүрдүүлэх” чиглэлээр дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

4.4.1. иргэдэд насан туршдаа суралцах хэрэгцээг нь хангасан, тэдний нас, сонирхол, авьяас чадвар, хөгжлийн онцлогт нийцсэн, тэгш боломжтой, олон хувилбарт, нээлттэй, хүртээмжтэй, чанартай боловсрол олгох;

4.4.2. стандартын шаардлага хангасан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд сургуулийн өмнөх насны нийт хүүхдийн 80 хувийг хамруулах нөхцөлийг бүрдүүлж, монгол хэл, сэтгэлгээний үндсийг эзэмшүүлэх;

4.4.3. бүх нийтийн ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй, чанартай олгох, олон улсын жишигт нийцсэн сурч боловсрох таатай орчныг бүрдүүлж, боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;

4.4.4. хүүхдийг үндэсний үнэт зүйлсийг өвлөсөн, бие даасан, бусдын эрхийг хүндэтгэдэг, хүмүүнлэг, ёс зүйтэй, амьдралын эрүүл хэвшилтэй, хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэх;

4.4.5. хөгжлийн бэрхшээлтэй зэрэг тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай иргэдийн боловсролын хэрэгцээг хангах, боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдах орчныг бүрдүүлэх;

4.4.6. өсвөр насны хүүхдэд ирээдүйд эзэмших мэргэжлээ зөв сонгох чадвар, дадал олгох, насан туршийн боловсролын үндсэн ойлголтыг эзэмшүүлэх, сэтгэлгээг хөгжүүлэх;

4.4.7. залуучууд олон улсын жишигт нийцсэн чанартай боловсролыг эх орондоо эзэмших боломжийг бий болгож, хөдөлмөрийн даяарчлагдсан зах зээлд өрсөлдөх мэдлэг, ур чадвартай залуу үеийг төлөвшүүлж, мэргэжлийн боловсролын чанар, мэргэжлийн боловсролын сургалтад хамрагдагчдын хамрагдалтын түвшинг нэмэгдүүлэх;

4.4.8. ажилтны мэдлэг, мэргэжлийг хүний нөөцийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан дээшлүүлэх, ажлын байранд нь мэргэшүүлэн дадлагажуулж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;



4.4.9. ахмад настны суралцах, хөгжих нөхцөл, боломжийг бүрдүүлэн дэмжиж, шинэ техник, технологи эзэмшин ашиглах, өөрийн мэдлэг, ажлын туршлага, ур чадвараа залуу үедээ өвлүүлэхийг дэмжих.

4.5. “Хүн амыг ажилтай, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэх” чиглэлээр дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

4.5.1. байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн чадамжид тохирсон ажлын байрыг бий болгохыг урамшуулах;

4.5.2. хөдөлмөр эрхлэх хүсэлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэх, хувийн бизнес эрхлэхэд нь гарааны дэмжлэг үзүүлж зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхтэй байдлыг 68 хувьд, ажилгүйдлийн түвшинг 4 хувьд хүргэх;

4.5.3. их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн төгсөгчдийг байнгын ажлын байртай болоход бүх талын дэмжлэг үзүүлэх;

4.5.4. хүн амын хөдөлмөр эрхлэх сонирхлыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэн ажилтны амьдрал ахуйд хүрэлцэхүйц цалин хөлс, нийгмийн баталгааг бий болгох;

4.5.5. эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх;

4.5.6. орон гэргүй, тэнэмэл, ажилгүй, ядуу хөдөлмөрийн чадвартай иргэдийг мэргэжлийн боловсролын сургалтад хамруулж, ажил хөдөлмөрт татан оролцуулж, байнгын ажил, орлоготой болгох;

4.5.7. орлогын тэгш бус байдлыг багасгах, ядуурлын түвшинг нэг оронтой тоонд хүргэх, нийгмийн дундаж болон чинээлэг дундаж давхаргын нийт хүн амд эзлэх хувийг 60 хувьд хүргэх.

4.6. “Хүн амын эрүүл, идэвхтэй насжилтыг дэмжих” чиглэлээр дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

4.6.1. үндэсний онцлог, хүн амын насны бүтцийн өөрчлөлтөд нийцүүлэн амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог хөгжүүлэх, эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдалтын хувийг 95-д хүргэх;

4.6.2. ахмад настан бүрийг тэтгэвэр, орлогын баталгаагаар хангах;

4.6.3. ахмад настанд зориулсан нийгмийн суурь үйлчилгээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх;

4.6.4. эрүүл, идэвхтэй насжилтын орчныг бүрдүүлэх, ахмад настан нийгмийн амьдралд идэвхтэй оролцох нөхцөлийг бүрдүүлэх.

Тав. Бодлогыг хэрэгжүүлэх арга зам, үе шат,
нөөц, санхүүжилтийн эх үүсвэр

5.1. Хүн амын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг улс орны хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлнэ.

5.2. Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг 2016-2025 онд дараах 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

5.2.1. нэгдүгээр үе шат: 2016-2020 он;

5.2.2. хоёрдугаар үе шат: 2021-2025 он.

5.3. Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.3.1. улс, орон нутгийн төсөв;

5.3.2. гадаадын зээл, тусламж;

5.3.3. гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;

5.3.4. бусад эх үүсвэр.

5.4. Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг салбар хоорондын түвшинд хэрэгжүүлэх зорилго, зорилтыг тухайн салбарын асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын, салбарын, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсөв, хөтөлбөр, хууль тогтоомжийг боловсруулж хэрэгжүүлэхэд иш үндэс болгож, шаардагдах хөрөнгийг жил бүрийн улс, орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлнэ.

5.5. Засгийн газар хүн ам, гэр бүлийн хөгжлийн чиглэлээр үндэсний хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх бөгөөд мэргэшсэн ажилтныг бэлтгэж, мэдлэг, мэргэшлийг нь дээшлүүлнэ.

Зургаа. Бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

6.1. Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газраас баталсан нийтлэг журмын дагуу гүйцэтгэнэ.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 5 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 276

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2011 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 375 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгох журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

ХӨДӨЛМӨРИЙН САЙД

Г.БАЯРСАЙХАН

Засгийн газрын 2016 оны 276 дугаар
тогтоолын хавсралт

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГААС ЖИЖИГ ЗЭЭЛ
ОЛГОХ, ТҮҮНД БАТЛАН ДААЛТ ГАРГАХ, ХҮҮГ НӨХӨН ТӨЛӨХ,
САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.2, 12.4, 12.6, 12.8.4, 12.9-т заасны дагуу иргэн, аж ахуйн нэгжид жижиг зээл олгох, зээлд батлан даалт гаргах, зээлийн хүүг нөхөн төлөх болон бусад санхүүгийн дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгох, зээлийн хүүгийн төлбөрийг нөхөн төлөх, зээлд батлан даалт гаргах үйл ажиллагаа нь өрхийн болон хувиараа хөдөлмөр эрхлэх, хоршоо, нөхөрлөл байгуулах, бичил аж ахуй эрхлэх, өргөтгөх, ажлын байр шинээр бий болгох, хадгалах боломжийг бүрдүүлэхэд чиглэнэ.

Хоёр. Жижиг зээл олгох

2.1. Жижиг зээлийг бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжид олгоно.

Иргэн бусадтай хамтран нөхөрлөл, хоршоо, 8-10 гишүүнтэй бүлэг байгуулж аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжиж болно.

2.2. Энэ журмын 2.1-д заасан иргэдийн бүлэг жижиг зээл олгох, зээлд батлан даалт гаргах үйл ажиллагаанд бүлгийн гишүүдийн хурлаас томилсон эрх бүхий төлөөлөгчөөр дамжуулан оролцоно.

2.3. Иргэн, аж ахуйн нэгж жижиг зээл хүссэн өргөдлөө холбогдох төслийн хамт аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтанд хүргүүлнэ. Төсөл нь дараах шаардлагыг хангасан байна:

2.3.1. хүрэх үр дүн, зорилт тодорхой байх;

2.3.2. ажиллах хүч, техник, тоног төхөөрөмжийн нөөц, боломж болон үйл ажиллагаа явуулах ажлын байр, орчныг сайтар тооцсон байх;

2.3.3. төслийн хүрээнд орон нутгийн онцлог, давуу талд түшиглэн өртөг шингэсэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл эрхлэхээр төлөвлөсөн байх;

2.3.4. зээлийн мөнгөн дүнгийн 40 болон түүнээс дээш хувьд хүрэлцэхүйц барьцаа хөрөнгөтэй байх;

2.3.5. төслийн хүрээнд байнгын ажлын байр бий болгож, цаашид хадгалах боломжтой байх.

2.4. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан нь иргэн, аж ахуйн нэгжийн зээл хүссэн өргөдлийг судалж, энэ журмын 2.3-т заасан шаардлагыг хангасан тохиолдолд зээл олгох саналаа тодорхойлолтын хамт банкинд хүргүүлнэ.

2.5. Банкнаас жижиг зээл олгох шийдвэр гарсны дараа аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан зээлдэгчтэй ажлын байр бий болгох, өргөтгөх, тогтвортой хадгалах талаар гэрээ байгуулж, зээлдэгчийн санхүүгийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх сургалт, уулзалтыг зохион байгуулах бөгөөд бизнес, аж ахуйн үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллана.

2.6. Жижиг зээл олгох банкиг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сонгон шалгаруулах бөгөөд



шалгарсан банктэй гэрээ байгуулж, тухайн жилд төсөвлөсөн зээл, зээлийн батлан даалтын хөрөнгийг дансанд нь байршуулна.

Гэрээнд зээлийн хөрөнгийг банкны дансанд байршуулах болон зээл олгох нөхцөл, зээлийн хөрөнгийн үлдэгдлийг эргүүлэн татах хугацаа, хариуцлагыг тодорхой заана.

2.7. Жижиг зээл олгох банк дараах нөхцөлийг хангасан байна:

2.7.1. Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, заавал байлгах нөөцийн шаардлагыг сүүлийн 10 сард хангасан байх бөгөөд энэ талаар Монголбанкны дүгнэлтийг хавсаргасан байна;

2.7.2. зээлийн үйл ажиллагаатай холбоотой аливаа эрсдэлийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн өмнө хариуцах баталгаа гаргасан байх;

2.7.3. жижиг зээлийн хүүгийн хэмжээ тухайн банкны зээлийн хүүгийн доод түвшингээс бага байх бөгөөд гэрээний туршид банкны олгож байгаа хүүгийн доод түвшингээс доогуур байх;

2.7.4. энэ журмын 2.6-д заасан сонгон шалгаруулалтын үеэр тавьсан бусад шаардлагыг хангасан байх.

2.8. Банкинд байршуулсан зээлийн хөрөнгөд аливаа хүү, төлбөр төлөхгүй.

2.9. Банк иргэн, аж ахуйн нэгжийн зээл авах болон зээлийн батлан даалтад хамрагдах хүсэлтийг ажлын 5 хоногт багтаан судалж шийдвэрлэнэ.

2.10. Жижиг зээлийг 24 сарын хугацаатай олгох бөгөөд үндсэн зээлээс чөлөөлөх хугацаа 6 сар хүртэл байна.

2.11. Жижиг зээлийн хэмжээ иргэнд 10.0 сая хүртэл, иргэдийн бүлэгт нэг гишүүнд 2.0 сая хүртэл, аж ахуйн нэгжид 20.0 сая хүртэл төгрөг байна.

2.12. Зээлийг хуваарийн дагуу төлж, зориулалтын дагуу зарцуулсан, үйл ажиллагаа нь тогтворжиж, гэрээнд заасны дагуу ажлын байр шинээр бий болгож тогтвортой хадгалсан, ажилчдаа нийгмийн даатгалд даатгуулсан зээлдэгч Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дахин зээл авах тохиолдолд зээлийн хугацааг 36 сар, үндсэн зээлээс чөлөөлөх хугацааг 12 сар хүртэл болгон нэмэгдүүлж, зээлийн хүүд хөнгөлөлт үзүүлнэ.

Зээлийн хүүгийн хөнгөлөлтийн хэмжээг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жижиг зээл олгох банктэй тохирч, энэ журмын 2.6-д заасан гэрээнд тусгана.

2.13. Зээлийн хөрөнгөөр өртөг шингэсэн үйлдвэрлэл эрхэлж, нэмүү өртгийн сүлжээнд хамрагдсан зээлдэгч Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дахин зээл авах тохиолдолд зээлийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлж болно.

2.14. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй бөгөөд зээлээ төлж дууссан боловч ашиглалтын явцад зээлийг зориулалтын бусаар ашигласан нь тогтоогдсон тохиолдолд тухайн зээлдэгчийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дахин жижиг зээл авах эрхийг 36 сар хүртэл хугацаагаар хязгаарлана.

Гурав. Зээлд батлан даалт гаргах

3.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.2-т заасан малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих зориулалтаар олгосон жижиг зээлд батлан даалт гаргана.

3.2. Энэ журмын 3.1-д заасан батлан даалтыг банкны зээл олгох бусад шалгуур үзүүлэлтийг хангасан ч барьцаа хөрөнгийн дутагдалтай иргэн, аж ахуй нэгжийн авч байгаа жижиг зээлд гаргах бөгөөд нэг зээлдэгчид гаргах батлан даалтын хэмжээ олгох зээлийн 60 хүртэлх хувьтай тэнцүү байна.

3.3. Зээлийн батлан даалтын хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

3.3.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө;

3.3.2. гадаад, дотоодын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн хөрөнгө;

3.3.3. бусад.

3.4. Зээлд батлан даалт гаргах нөхцөл, талуудын эрх, үүрэг, хариуцлага, батлан даалтын төлбөр төлөх, батлан даалтыг түдгэлзүүлэх, зогсоох, хяналт тавих, тайлагнахтай холбогдсон харилцааг “Батлан даалтын гэрээ”-нд тусган хэрэгжүүлнэ.

“Батлан даалтын гэрээ”-ний загварыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

Дөрөв. Зээлийн хүүг нөхөн төлөх

4.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.4-т заасан ажил олоход хүндрэлтэй иргэн материал, түүхий эд, үр, бордоо, мал, тэжээвэр амьтан, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авахад зориулж жижиг зээл авсан бол хүүгийн төлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас



нөхөн төлөх бөгөөд ийнхүү төлөхдөө иргэний хүсэлт, зээлийн гэрээ, зээл, зээлийн хүүгийн төлбөрийг банкинд төлсөн баримт болон санхүүгийн бусад баримтыг үндэслэнэ.

4.2. Энэ журмын 4.1-д заасан иргэний хүсэлтийг мөн журмын 2.9-т заасан хугацаанд судалж шийдвэрлэнэ.

4.3. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага (сан) энэ журмын 4.1-д заасан зээлийн хүүгийн төлбөрийн тухайн жилд ногдох хэсгийг жил бүрийн эхний улиралд багтаан зээлдэгчид нөхөн төлнө.

Тав. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх

5.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6.3.7, 28.8.2-т заасны дагуу Засгийн газар болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан төсөл, хөтөлбөрийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг олгоно.

5.2. Энэ журмын 5.1-д заасан санхүүгийн дэмжлэгийн төрөл, хэмжээ, нөхцөл, шаардлагыг тухайн төсөл, хөтөлбөрт, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөх хуваарийг төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэрээнд тус тус тусгана.

5.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.1-д заасан малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнд ганцаараа болон бусадтай хамтран аж ахуй эрхэлхэд зориулж үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн хэмжээ нэг төсөлд 5.0 сая хүртэл төгрөг байх бөгөөд уг санхүүгийн дэмжлэгийн 30-аас дээш хувийг эргэн төлнө.

5.4. Санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөх хуваарь санхүүгийн дэмжлэг үзүүлсэн 4 дэх сараас эхэлж 20 хүртэлх сарын хугацаанд сар бүр ижил хэмжээгээр төлөх нөхцөлтэй байна.

5.5. Энэ журмын 5.3-т заасан этгээдийн санхүүгийн дэмжлэгт дахин хамрагдах хугацаа 24 ба түүнээс дээш сарын дараа байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна:

5.5.1. гэрээний хугацаа бүрэн дууссан байх;

5.5.2. санхүүгийн дэмжлэгийн үр дүнг тооцсон байх;

5.5.3. санхүүгийн дэмжлэгийн хөрөнгийг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан болон эргэн төлөлтийг төлж барагдуулсан байх.

5.6. Энэ журмын 5.3-т заасан этгээдийн санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтийг мөн журмын 2.9-т заасан хугацаанд судалж шийдвэрлэнэ.



Зургаа. Хяналт тавих, тайлагнах

6.1. Энэ журамд заасны дагуу жижиг зээл олгосон, батлан даалт гаргасан, хүүг нөхөн төлсөн болон санхүүгийн дэмжлэг үзүүлсэн талаарх мэдээллийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 17.1-д заасан хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд тухай бүр бүртгүүлж, мэдээллийн сан үүсгэнэ. Бүртгэлийн маягтыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

6.2. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага энэ журмын 6.1-д заасан мэдээллийн санд тулгуурлан сар бүр тайлан бэлтгэж дараа сарын 3-ны өдрийн дотор хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Тайлангийн маягтыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

6.3. Энэ журмын 6.1, 6.2 дахь заалтын хүрээнд банк аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтныг тогтоосон хугацаанд мэдээллээр тогтмол хангаж, хамтарч ажиллана.

6.4. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан улирал тутам нийт зээлдэгчийг хамруулан зээлийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт, шалгалт хийнэ.

Хяналт, шалгалтын дүнг тухай бүр хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

6.5. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сумын хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан ажилтан банкны жижиг зээл олгох, зээлд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх үйл ажиллагааны гүйцэтгэл болон банкинд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас байршуулсан хөрөнгийн зарцуулалтад улирал тутам хяналт тавьж ажиллана.

Хяналтын тайлан, дүгнэлтийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр хүргүүлнэ.

6.6. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтэд хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөл болон аймаг, дүүргийн салбар зөвлөл хяналт тавьж ажиллана. Шаардлагатай тохиолдолд уг үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагаар хяналт, шалгалт хийлгэж болно.

6.7. Энэ журмын 6.4-6.6-д заасан хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах үүргийг гэрээ байгуулсан талууд хариуцна.



6.8. Жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь хяналт, шалгалтаар тогтоогдсон бол хөрөнгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

6.9. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хууль бусаар ашигласан гэж буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 5 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 288

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Номын сангийн тухай хуулийн 20.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Улсын болон орон нутгийн номын сангийн сан хөмрөгийг байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын үед улсын болон орон нутгийн номын санг нүүлгэн шилжүүлэх ажлын бэлтгэлийг сайтар хангуулж, хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөрт, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Л.ГАНТӨМӨР

Засгийн газрын 2016 оны 288 дугаар
тогтоолын хавсралт

**УЛСЫН БОЛОН ОРОН НУТГИЙН НОМЫН САНГИЙН САН ХӨМРӨГИЙГ
БАЙГАЛИЙН ГАМШИГ, ГЭНЭТИЙН БУСАД АЮУЛЫН ҮЕД
НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Улсын болон орон нутгийн номын сангийн сан хөмрөгийг (цаашид “сан хөмрөг” гэх) байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулаас урьдчилан сэргийлэх, гамшиг, аюулын үед нүүлгэн шилжүүлэхтэй холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.



1.2. Сан хөмрөгийг авран хамгаалах зорилгоор гамшигт өртсөн нөхцөл байдлыг харгалзан түр хугацаагаар буюу бүрмөсөн аюулгүй орчинд нүүлгэн шилжүүлэлт хийж болно.

1.3. Сан хөмрөгийг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаанд Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгийн үеийн дайчилгаа, нүүлгэн шилжүүлэх журам болон энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Улсын болон орон нутгийн номын сангийн сан хөмрөгийг байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулаас урьдчилан сэргийлэх

2.1. Номын сан нь байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах арга хэмжээг авна:

2.1.1. гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх чиглэлээр эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг биелүүлэх;

2.1.2. номын сангийн аюулгүй байдлын шаардлагыг хангасан техникийн дотоод дүрэм, журам, стандарт, барилгын норм, нормативыг дагаж мөрдөх;

2.1.3. гамшгаас хамгаалах болон гамшгийн үед ажиллах, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө, нүүлгэн шилжүүлэлтийн үед баримтлах зааврыг эрх бүхий байгууллагаар батлуулж хэрэгжүүлэх;

2.1.4. номын санг гамшгаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр иж бүрэн тоноглох;

2.1.5. гамшгийн үед номын сангийн сан хөмрөгийг аврах, ажиллагсдыг гамшгаас хамгаалах болон гамшгийн үеийн үйл ажиллагаанд сургаж бэлтгэх, гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх дадлага, чадвартай болгох, бэлэн байдлыг хангуулах;

2.1.6. нүүлгэн шилжүүлэх бэлэн байдлыг хангах зорилгоор дадлага, сургуулилтыг онцгой байдлын асуудал хариуцсан байгууллагатай хамтран тогтмол зохион байгуулах;

2.1.7. гамшигт өртөж болох эрсдэлийг тооцоолж, эрсдэлийн үнэлгээ (геологийн, газар зүйн, цаг уурын, барилга байгууламжийн, ашиглалт үйлчилгээний гэх мэт) хийлгэх, эрсдэлийг эрэмбэлэх;

2.1.8. олон улсад шинээр нэвтрүүлж байгаа дэвшилтэт технологи, стандартыг судалж нэвтрүүлэх;

2.1.9. гамшгаас сэргийлэхэд чиглэсэн сургалт, шаардлагатай техник, тоног төхөөрөмж худалдан авах зардлыг жил бүрийн төсөв, төлөвлөгөөндөө тусгах.



Гурав. Сан хөмрөгийг нүүлгэн шилжүүлэх, санхүүжилт

3.1. Тухайн нутаг дэвсгэрийн Засаг дарга сан хөмрөгийг нүүлгэн шилжүүлэх шийдвэрийг гаргаж, нүүлгэн шилжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах тусгай бүлгүүдийн удирдлагыг томилж, бүлгийн гүйцэтгэх үүргийг тогтооно.

3.2. Онцгой байдлын асуудал хариуцсан байгууллага Гамшгаас хамгаалах тухай хууль болон Гамшгийн үеийн дайчилгаа, нүүлгэн шилжүүлэх журмын дагуу нүүлгэн шилжүүлэлтийг зохион байгуулж байгаа бүх шатны Засаг даргад мэргэжлийн дэмжлэг үзүүлж, оролцогч байгууллагыг удирдлага, зохицуулалтаар хангана.

3.3. Хосгүй үнэт, үнэт ховор ном судар, гар бичмэл, эх хувийг эхний ээлжинд тээвэрлэлтэд бэлтгэн аюулгүй бүс рүү цагдаагийн байгууллагын хамгаалалт дор гүйцэтгэж болно.

3.4. Нүүлгэн шилжүүлэлтийн үед баримтлах зааврыг оролцогч байгууллагууд чанд мөрдөнө.

3.5. Ном, судрыг зөөж тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй, найдвартай ажиллагааны норм, стандарт болон хууль тогтоомжид заасан бусад шаардлагыг хангасан байна.

3.6. Орон нутгийн номын сангийн сан хөмрөгийг нүүлгэн шилжүүлэх зардлыг аймаг, нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс, Үндэсний номын сан, Хүүхдийн төв номын сангийн сан хөмрөгийг нүүлгэн шилжүүлэх зардлыг Засгийн газрын нөөц хөрөнгөөс тус тус санхүүжүүлнэ.

3.7. Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлсэн нүүлгэн шилжүүлэх зардлыг орон нутгийн дараа жилийн төсвийн багцад тусгана.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 5 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 292

Улаанбаатар
хот

Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэврийг 2016 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 21.000



(хорин нэгэн мянган) төгрөгөөр нэмэгдүүлэн тооцож олгохыг Сангийн сайд Б.Болор, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэ нарт даалгасугай.

2. Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны бүрэн тэтгэврийн доод хэмжээг 251.000 (хоёр зуун тавин нэгэн мянган) төгрөгөөр, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 216.000 (хоёр зуун арван зургаан мянган) төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” Засгийн газрын 2015 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 52 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн “б”, “в” заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

**ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

С.ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 5 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 293

Улаанбаатар
хот

**Нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны
тэтгэмжийн хэмжээг шинэчлэн
тогтоох тухай**

Нийгмийн халамжийн тухай хуулийн 16.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 2016 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн сард 140.000 (нэг зуун дөчин мянган) төгрөгөөр, асаргааны тэтгэмжийн хэмжээг сард 64.000 (жаран дөрвөн мянган) төгрөгөөр тус тус тогтоон мөрдсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2015 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 53 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

**ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

С.ЭРДЭНЭ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 6 дугаар
сарын 9-ний өдөр

Дугаар 314

Улаанбаатар
хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 4.1.2, 5.1.8, 7, 12, 13 дугаар зүйлд заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. ““Сайн оюутан” хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2016 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 229 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан ““Сайн оюутан” хөтөлбөрийн зээлийн ерөнхий журам”-ын 2.3.3, 3.4.2 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

а) “2.3.3. хугацаа (жил): цалин, тэтгэврийн зээлийн дуусах хугацаагаар.”

б) “3.4.2. зээлийг банкнаас 2016 оны 4 дүгээр сарын 25-ны өдрөөс өмнө авсан байх;”

2. Мөн журмын 3.6.2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Л.ГАНТӨМӨР

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2.75

Индекс: 14003